



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 11157

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн 118 дугаар сургуулийн<sup>1</sup>  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 17,855,120.58 (арван долоон сая найман зуун тавин таван мянга нэг зуун хорин төгрөг тавин найм мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль (Ц.Мөнхтөр)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 10954 ширхэг 17,855,120.58 (арван долоон сая найман зуун тавин таван мянга нэг зуун хорин төгрөг тавин найм мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 118 дугаар сургууль (Ц.Мөнхтөр)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА




М.БАЯРАА

115050000443

Тушаал 2021

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын  
 даргын 2021 оны 26 дугаар сарын 07-ны өдрийн  
 11/197 дугаар тушаалын хавсралт



Актлах сурах бичгийн жагсаалт

Байгууллага: ХУД-ын 118 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн шийдвэр	байгууллагын үнийн санал	НӨАУГ-ын мэргэжилтэний дүгнэлт	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	8	ш	10,954.00		17,855,120.58	-	Агуулга стандарт өөрчлөгдсөн, хуучирч элэгдсэн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй.	актлах	устгах	устгах	устгах
	Нийт			10,954.00		17,855,120.58						